



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 00 өдөр

Дугаар 14

Мандалговь

Г
Т.Төрбатыг аймгийн Стандарт хэмжил зүйн
хэлтсийн Салбар сан хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн Салбар сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Тэрбишийн Төрбат 75.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Төрбатын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын
10-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



**Стандарт хэмжил зүйн хэлтсийн Салбар сан хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн
Т.Төрбатын тухай дүгнэлт**

1. Т.Төрбат нь 1977 онд Дундговь аймгийн Хулд суманд төрсөн. 45 настай, эрэгтэй
2. Боловсролын байдал: 1995-1999 онд Монгол улсын их сургуулийг цөмийн физикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2000-2008 онд Дэлхийн зөн ОУБ-д хөтөлбөрийн зохицуулагч, 2008-2010 онд Азийн хөгжлийн банкны эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр - 3-ийн зохицуулагч, 2010-2016 онд Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторын эрхлэгч, улсын шалгагч, 2016-2019 онд НИК ХХК-ны орон нутгийн салбарын захирлаар ажиллаж байсан.
4. Т.Төрбатын төрийн албанд ажилласан туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Стандарт хэмжил зүйн хэлтсийн Салбар сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ